



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 663

Улаанбаатар хот

Г Б.Халиуныг ажилд томилох тухай Г

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гадаад харилцааны сайдын 2024 оны 08/3194 дүгээр албан бичгээр ирүүлсэн санал, Авлигатай тэмцэх газрын 2024 оны 05/15334 дүгээр албан бичгээр ирүүлсэн дүгнэлт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2024 оны А/64 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар байгуулагдсан “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн дүгнэлтийг тус тус харгалзан “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлаар Болдбаатарын Халиуныг 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс томилсугай.

2. Б.Халиунтай Онцгой нэхцэл бүхий хөдөлмөрийн гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

130002852

29-r huraldaan.docx